



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/26/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Сайншанд хот  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: [Dornogovi@audit.gov.mn](mailto:Dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: [enkhtsetseg.e@audit.gov.mn](mailto:enkhtsetseg.e@audit.gov.mn)

Аудитор: О.Нарангарав

Утас: 70523020 Цахим хаяг: [Narangarav.o@audit.gov.mn](mailto:Narangarav.o@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал .....	12
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	14
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	22

## Аудитын гэрчилгээ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020.02.21 № 1-6/112  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Д.ГАНТӨМӨР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020010

### Аудитын гол асуудал

1. Байгууллагын даргын буюу 1-р гарын үсэг, тамга тэмдэг, төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй төлбөрийн хүсэлтээр нийт 23,958.9 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, харилцах дансны хуулгаар 9,122.8 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн боловч холбогдох төлбөрийн хүсэлт, анхан шатны баримт байхгүй байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 37.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.7, Засгийн газрын 2015 оны 24-р тогтоолын 7.5, 8.6 дахь заалтуудыг тус тус зөрсөн.
2. Албан хаагчийн албан тушаалын цалинг буруу тогтоосон, цалингийн сахилгын шийтгэлийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, цалин илүү тооцож олгосон, цалингийн урьдчилгааг суутгаагүй зэрэг нийт 924.1 мянган төгрөгийн зөрчил гаргасан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 20.2.5, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын 3.5.8, 3.5.12 дахь заалтуудыг тус тус зөрсөн.
3. Албан томилолтын хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, томилолтын тооцооллыг буруу хийснээс нийт 5 албан хаагчид 2,926.0 мянган төгрөгийн албан томилолтыг илүү тооцож олгосон нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.7, Засгийн газрын 2019 оны 6-р тогтоолын 2 дахь зүйл заалт, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалыг тус тус зөрсөн байна.

Эдгээр нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг байгууллагын дарга Д.Гантөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-аас 2020 оны 02 дүгээр сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03/24 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сум багийн ажлыг уялдуулан оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, улмаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд чиглэгдэнэ”-д оршино.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 406,518.5 мянган төгрөгөөс тооцон 4,065.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 4,179.7 мянган төгрөгөөр тооцсон нь материаллаг байдлыг 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцсон тул өөрчлөн 2019 оны жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзэн нийт зардлын 1%-иар тодорхойлов.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,447.6 мянган төгрөгөөр буюу 1.05 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал 4,133.9 мянган төгрөг, өр төлбөр 1,731.9 мянган төгрөгөөр өсөж, авлага 294.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 13,286.9 мянган төгрөг, цэвэр хөрөнгө өмчийн дүн 11,179.5 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
				Дүн	Хувь
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,514.07</b>	<b>54,353.38</b>	<b>3,839.31</b>	<b>7.60</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
33	АВЛАГА	669.59	375.00	(294.60)	-44.00
34	УРЬДЧИЛГАА	-	-	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,844.48	53,978.38	4,133.90	8.29
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>848,278.73</b>	<b>834,991.79</b>	<b>(13,286.93)</b>	<b>-1.57</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	848,278.73	834,991.79	(13,286.93)	-1.57
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>898,792.80</b>	<b>889,345.17</b>	<b>(9,447.63)</b>	<b>-1.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,027.63</b>	<b>3,759.52</b>	<b>1,731.89</b>	<b>85.41</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,027.63	3,759.52	1,731.89	85.41
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>896,765.17</b>	<b>885,585.65</b>	<b>(11,179.52)</b>	<b>-1.25</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>898,792.80</b>	<b>889,345.17</b>	<b>(9,447.63)</b>	<b>-1.05</b>

Авлага дансны үлдэгдэл 294.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнө оны авлага 315.0 мянган төгрөгөөр буурч, тайлант онд 20.4 мянган төгрөгийн цалингийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,133.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг 67.5 мянган төгрөг, аж ахуйн материал 2,919.4 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, түлш шатах тослох материал 158.0 мянган төгрөг, мал амьтанд 195.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь барилга байгууламж 10,441.2 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 36,870.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 5,671.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,400.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 65,736.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 17,046.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 103,402.4 мянган төгрөгийн барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, бусад хөрөнгийг нэмж бүртгэсэн байна.

Биет бус хөрөнгө 330.0 мянган төгрөгөөр өссөн нь архивын бүртгэлийн программ хангамжийг худалдан авсан холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 133,735.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг нэмж цэвэр үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 13,286.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,731.9 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн өглөг 2,861.3 мянган төгрөгөөр өсөж, бусад өр төлбөр 1,129.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Тайлант оны цалингийн зардлын гүйлгээнүүдийг шилжүүлсэн дүнгээр зардалд бүртгэж хоорондын тооцоолол үүсэж бүртгээгүйгээс 2,861.3 мянган төгрөгийн цалингийн өглөгийг тайлагнаагүй байсныг аудитаар залруулан бүртгэсэн нь өр төлбөр нэмэгдэхэд шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 885,585.6 мянган төгрөг болж 11,179.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсан нь шалтгаалжээ. Энэ нь тайлант онд нэмэгдсэн элэгдлийн зардалтай холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газарт тайлант онд 250.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 250.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Данс ны код	Орлогын ангилал	Тайлант оны		Тайлант оны зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1310	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,347.60	283,097.60	250.00	99.9
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	250.00	250.00	-	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>283,597.60</b>	<b>283,347.60</b>	<b>250.00</b>	<b>99.9</b>

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 283,597.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 283,597.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 283,347.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 250.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсвөөс 283,097.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 250.0 мянган төгрөг нийт 283,347.6 мянган төгрөгийн санхүүжилттэй ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 282,384.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна. Үүний: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 213,581.4 мянган төгрөг нь нийт зардлын 75.6 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 68,003.1 мянган төгрөг нь нийт зардлын 24.1 хувь, урсгал шилжүүлгийн зардал 800.0 мянган төгрөг нь нийт зардлын 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Жилийн эцэст орон нутгийн санхүүжилтийн дутуу 250.0 мянга, урсгал зардлын хэмнэлт 1,213.1 мянган төгрөгийн зөрүү хэмнэлт 963.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллого, барилга орон сууцны тооллогын санхүүжилт нийт 2,034.7 мянган төгрөг, ХХААГ-аас оготно устгалын санхүүжилт 8,700.0 мянган төгрөг, ХХҮГ-аас харьяалалгүй ахмадын санхүүжилт 1,660.0 мянган төгрөг, АЗДТГ-аас 10,000.0 мянган төгрөгийн дэмжлэг зэргийг олгож, цахим тендерийн орлого 396.0 мянган төгрөг, мал бойны газрын түрээсийн орлого 240.0 мянга нийт 23,030.7 мянган төгрөгийн орлогыг холбогдох дансанд бүртгэсэн байна.

Нийт санхүүжилтийг зарцуулах эрхийг зохих журмын дагуу нээлгэн холбогдох үйл ажиллагаануудад зарцуулсан байна. АЗДТГ-ын олгосон дэмжлэгээр тулга хийлгэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 334.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 45,014.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,696.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,830.1 мянган төгрөгийн зөрчилд 5 акт тогтоож, 33,081.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5,405.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 36,911.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснээс 3,830.1 мянган төгрөгийн зөрчилд 5 акт тогтоож, 33,081.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

### **1. Зардлын данстай холбоотой**

Байгууллагын даргын буюу 1-р гарын үсэг, тамга тэмдэг, төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй төлбөрийн хүсэлтээр нийт 23,958.9 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, харилцах дансны хуулгаар 9,122.8 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн боловч холбогдох төлбөрийн хүсэлт, анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 37.1.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.7, Засгийн газрын 2015 оны 24-р тогтоолын 7.5, 8.6 дахь заалтуудыг тус тус зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **2. Зардлын данстай холбоотой**

Төрийн сангийн мэргэжилтэн ажилтай Ч.Шүрэнцэцэгт 2019 оны 6 дугаар сард 500.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалинг олгоод 300.0 мянган төгрөгийг суутгаж, 200.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, нягтлан бодох бүртгэлд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **3. Зардлын данстай холбоотой**

Албан томилолтын хуудас байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, томилолтын тооцооллыг буруу хийснээс нийт 5 албан хаагчид 2,926.0 мянган төгрөгийн албан томилолтыг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 6-р тогтоолын 2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал зэргийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **4. Зардлын данстай холбоотой**

Аймгийн Засаг даргын Б/23 дугаар захирамжаар сумын засаг даргад үндсэн цалингийн 19 хувиар 1 сар, сумын Засаг даргын тамгын газрын даргын Б/11 дүгээр тушаалаар мэргэжилтэн Д.Түвшинжаргалд цалингийн 19 хувиар 3 сар тус тус сахилгын шийтгэл оногдуулсан байна. Гэтэл нягтлан бодогч тооцооллыг буруу хийснээс Засаг дарга Д.Дуламаас 193,033 төгрөг, мэргэжилтэн Д.Түвшинжаргалаас 222,524 төгрөг нийт 415,577 төгрөгийг суутгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **5. Зардлын данстай холбоотой**

Сумын Засаг даргын 2019 оны Б/04 дүгээр захирамжаар сумын боловсрол, соёл хариуцсан нягтлан бодогч Г.Одончимэгийг орон нутгийн төсөв хариуцсан нягтлан бодогчийн ажил албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингийн буюу Засгийн газрын 2019 оны 24-р тогтоолын 9-р хавсралтын ТҮ-8-3-ийн 667,449 төгрөгийн 30 хувиар тооцож олгохоор шийдвэрлэсэн байна. Гэтэл нягтлан бодогчийн үүргийг хавсран гүйцэтгэгч Г.Одончимэгт 2019 оны 2, 3 дугаар саруудад үндсэн цалингийн 40 хувиар тооцож нийт 133,490 төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **6. Зардлын данстай холбоотой**

Орон нутгийн төсөв хариуцсан нягтлан бодогч Г.Цээпилмаагийн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 9 дүгээр хавсралтын ТҮ-8-1-ийн 648,977 төгрөгөөр тогтоох байтал сумын Засаг даргын 2019 оны Б/14 дүгээр захирамжаар тус тогтоолын 10 дугаар хавсралтын ТҮ-8-1-ийн 677,193 төгрөгөөр буруу тогтоосноос нягтлан бодогч Г.Цээпилмаад 175,006 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн 13.6, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалын 3.5.8, 3.5.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 5,405.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Мал амьтадын бүртгэлийг авч үзэх шаардлагатай.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 84 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 61 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар нь өмнө онд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлээгүйгээс цаг хугацааны хязгаарлалтад орж дүгнэлт өгөхөөс татгалзсан учир акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Хязгаарлалттай” дүгнэлт**

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого үйл ажиллагаатай холбоотой**

**1.1. Илрүүлэлт:** Тайланд онд 21,279.7 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хоорондын тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэснээс 4,296.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын тайланд бүртгэлгүй шууд зардалд бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, 14.4 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

**1.2 Эрсдэл:** Дотоод хяналтын тогтолцоо сулрах, төсвийн сахилга бат алдагдах, бараа материал дутагдах, шамшигдах, санхүүгийн тайлан буруу тайлагнагдах эрсдэлтэй.

**1.3 Өгсөн зөвлөмж:** Цаашид Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу харилцах дансаар хийгдэж буй ажил гүйлгээнүүдийг тооцооны дансаар бүртгэж, бараа материалын холбогдох дансанд орлого, зарлагыг бүртгэж тайлагнах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Цэвэр бохир ус, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэлийн зардлуудыг зориулалт бусаар зарцуулж 1,109.7 мянган төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

**2.2 Эрсдэл:** Төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу тайлагнагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй.

**2.3 Өгсөн зөвлөмж:** Цаашид Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалд заасны дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөг/ Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>50,514,073.62</u></b>	<b><u>54,353,378.62</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	669,591.00	374,996.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	669,591.00	374,996.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	49,844,482.62	53,978,382.62
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	48,309,482.62	52,638,382.62
35410	Бичиг хэргийн материал	1,295,500.00	1,363,000.00
35420	Аж ахуйн материал	46,126,382.62	49,045,782.62
35430	Сэлбэг хэрэгсэл	255,600.00	1,755,600.00
35440	Түлш, шатах тослох материал	632,000.00	474,000.00
35600	Мал амьтад	1,535,000.00	1,340,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>848,278,727.69</u></b>	<b><u>834,991,794.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	848,278,727.69	834,991,794.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	802,650,727.97	789,216,794.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	331,833,373.00	342,274,573.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-12,643,908.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,321,300.00	224,191,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-147,469,405.04	-189,404,338.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,777,170.38	153,448,170.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-124,831,926.97	-137,830,532.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,983,659.00	28,383,659.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,906,736.99	-25,406,616.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	902,716,090.13	968,452,272.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-500,772,795.54	-562,247,782.73
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	45,627,999.72	45,775,000.00
39301	Програм хангамж	939,000.00	1,269,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-789,000.28	-972,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,478,000.00	45,478,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>898,792,801.31</u></b>	<b><u>889,345,173.58</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,027,633.00</u></b>	<b><u>3,759,523.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,027,633.00	3,759,523.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,027,633.00	3,759,523.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	777,573.00	3,638,890.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,067,600.00	65,673.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	182,460.00	54,960.00
41361	Байгууллагад төлөх өглөг	174,800.00	47,300.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,660.00	7,660.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>896,765,168.31</u></b>	<b><u>885,585,650.58</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	896,765,168.31	885,585,650.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	432,758,942.42	432,758,942.42
51101	Өмч: - төрийн	432,758,942.42	432,758,942.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	299,604,290.07	288,424,772.34
51210	Өмнөх үеийн үр дүн	299,604,290.07	299,604,290.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,179,517.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,401,935.82	164,401,935.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>898,792,801.31</u></b>	<b><u>889,345,173.58</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>323,594,661.00</b>	<b>409,870,659.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>70,744,859.00</b>	<b>103,742,382.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	70,744,859.00	103,742,382.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,744,859.00	103,742,382.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	250,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	70,744,859.00	103,492,382.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>252,849,802.00</b>	<b>306,128,277.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,941,602.00	23,030,677.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,941,602.00	23,030,677.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	241,908,200.00	283,097,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,908,200.00	283,097,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>456,125,901.87</b>	<b>421,050,176.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>454,750,901.87</b>	<b>420,765,176.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	451,688,153.87	417,257,297.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	174,220,672.00	193,252,086.00
210101	Үндсэн цалин	174,220,672.00	193,002,086.00
210104	Урамшуулал	00.00	250,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,994,345.00	23,735,255.00
210201	Тэтгэврийн даатгал	12,646,814.00	16,450,737.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,398,592.00	1,423,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,426,819.00	1,770,836.00
210204	Ажилгүйдлийн даатгал	344,634.00	371,859.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,177,486.00	3,717,931.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,176,797.00	7,504,341.00
210301	Гэрэл, цахилгаан	1,996,797.00	2,469,341.00
210302	Түлш, халаалт	10,180,000.00	4,814,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	221,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,071,532.00	20,350,327.00
210401	Бичиг хэрэг	2,673,170.00	3,352,600.00
210402	Тээвэр, шатахуун	17,803,752.00	12,170,377.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,029,400.00	3,151,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,469,710.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,095,500.00	1,639,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,320,600.00	107,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,320,600.00	107,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,335,000.00	969,600.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	30,000.00
210604	Урсгал засвар	1,335,000.00	939,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,736,100.00</b>	<b>8,186,700.00</b>
210701	Гадаад албан томилолт	00.00	60,000.00
210702	Дотоод албан томилолт	4,736,100.00	8,126,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,272,350.00</b>	<b>25,539,874.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,874,850.00	24,877,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	329,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,000.00	51,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	106,000.00
210807	Газрын төлбөр	314,500.00	175,744.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>198,560,757.87</b>	<b>137,612,114.73</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,876,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,560,757.87	133,735,314.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,062,748.00</b>	<b>3,507,879.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,790,000.00</b>	<b>2,210,000.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,790,000.00	1,410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>272,748.00</b>	<b>1,297,879.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	272,748.00	1,297,879.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,375,000.00</b>	<b>285,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,375,000.00</b>	<b>285,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	1,375,000.00	285,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-132,531,240.87</u></b>	<b><u>-11,179,517.73</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-180,038,162.87</u></b>	<b><u>-11,179,517.73</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>252,849,802.00</u></b>	<b><u>306,378,277.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>250,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	250,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	250,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	250,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>252,849,802.00</b>	<b>306,128,277.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,941,602.00	23,030,677.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,941,602.00	23,030,677.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	241,908,200.00	283,097,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,908,200.00	283,097,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>252,849,802.00</u></b>	<b><u>289,332,277.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>252,849,802.00</b>	<b>289,332,277.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>249,787,054.00</b>	<b>285,824,398.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	173,502,795.00	190,069,729.00
210101	Үндсэн цалин	173,502,795.00	189,819,729.00
210104	Урамшуулал	00.00	250,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,924,925.00	23,761,700.00
210201	Тэтгэврийн даатгал	14,086,306.00	16,101,657.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,609,472.00	1,755,522.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,426,819.00	1,503,727.00
210204	Ажилгүйдлийн даатгал	344,634.00	346,994.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,457,694.00	4,053,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,202,792.00	8,348,268.00
210301	Гэрэл, цахилгаан	1,972,392.00	1,849,304.00
210302	Түлш, халаалт	9,230,400.00	6,248,964.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,134,652.00	19,039,027.00
210401	Бичиг хэрэг	2,472,020.00	2,399,200.00
210402	Тээвэр, шатахуун	14,745,802.00	12,170,377.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,074,850.00	3,525,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,569,600.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	272,380.00	800,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	199,670.00	198,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	199,670.00	198,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,707,200.00	1,479,300.00
210604	Урсгал засвар	1,707,200.00	1,479,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,736,100.00	8,186,700.00
210702	Дотоод албан томилолт	4,736,100.00	8,186,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,378,920.00	28,610,674.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,981,420.00	27,948,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	329,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	86,000.00
210807	Газрын төлбөр	314,500.00	175,744.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>6,130,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,130,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,062,748.00</b>	<b>3,507,879.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,790,000.00</b>	<b>2,210,000.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,790,000.00	1,410,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>272,748.00</b>	<b>1,297,879.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	272,748.00	1,297,879.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>17,046,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>17,046,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>17,046,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>17,046,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	17,046,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>-17,046,000.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	387,280,942.42	43,015,877.68	495,316,762.54	<b>925,613,582.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>387,280,942.42</b>	<b>43,015,877.68</b>	<b>495,316,762.54</b>	<b>925,613,582.64</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-71,856,670.74	<b>-71,856,670.74</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>432,758,942.42</b>	<b>164,401,935.82</b>	<b>299,604,290.07</b>	<b>896,765,168.31</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>432,758,942.42</b>	<b>164,401,935.82</b>	<b>299,604,290.07</b>	<b>896,765,168.31</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>432,758,942.42</b>	<b>164,401,935.82</b>	<b>299,604,290.07</b>	<b>896,765,168.31</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	<b>00.00</b>
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-11,179,517.73	<b>-11,179,517.73</b>
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>432,758,942.42</b>	<b>164,401,935.82</b>	<b>288,424,772.34</b>	<b>885,585,650.58</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	283,602,800.00	282,384,521.00	1,218,279.00	99.57
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	283,602,800.00	282,384,521.00	1,218,279.00	99.57
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	282,802,800.00	281,584,521.00	1,218,279.00	99.57
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	190,993,400.00	189,819,729.00	1,173,671.00	99.39
Үндсэн цалин	190,993,400.00	189,819,729.00	1,173,671.00	99.39
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,466,900.00	23,761,700.00	(294,800.00)	101.26
Тэтгэврийн даатгал	15,953,900.00	15,953,900.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	1,876,900.00	1,877,000.00	(100.00)	100.01
ҮОМШӨ-ний даатгал	1,506,900.00	1,501,600.00	5,300.00	99.65
Ажилгүйдлийн даатгал	375,400.00	375,400.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	3,753,800.00	4,053,800.00	(300,000.00)	107.99
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,369,700.00	8,348,268.00	21,432.00	99.74
Гэрэл, цахилгаан	1,849,700.00	1,849,304.00	396.00	99.98
Түлш, халаалт	6,270,000.00	6,248,964.00	21,036.00	99.66
Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00	-	100.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,905,900.00	18,766,450.00	139,450.00	99.26
Бичиг хэрэг	3,450,800.00	3,445,900.00	4,900.00	99.86
Тээвэр, шатахуун	10,851,100.00	10,851,100.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,660,000.00	3,525,450.00	134,550.00	96.32
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	800,000.00	-	100.00
<b>Нормативт зардал</b>	200,000.00	198,300.00	1,700.00	99.15
Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	198,300.00	1,700.00	99.15
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,480,000.00	6,479,300.00	700.00	99.99
Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
Урсгал засвар	1,480,000.00	1,479,300.00	700.00	99.95
<b>Томилолт, зочны зардал</b>	8,237,900.00	8,186,700.00	51,200.00	99.38
Гадаад албан томилолт	-	666,000.00	(666,000.00)	#DIV/0!
Дотоод албан томилолт	8,237,900.00	7,520,700.00	717,200.00	91.29
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,249,000.00	19,124,074.00	124,926.00	99.35
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,462,000.00	18,461,400.00	600.00	100.00
Даатгалын үйлчилгээ	330,000.00	329,930.00	70.00	99.98
Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	86,000.00	-	100.00
Газрын төлбөр	180,000.00	175,744.00	4,256.00	97.64

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,900,000.00	6,900,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,900,000.00	-	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	800,000.00	800,000.00	-	100.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	800,000.00	800,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	-	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	283,602,800.00	283,347,600.00	255,200.00	99.91
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	283,352,800.00	283,097,600.00	255,200.00	99.91
Орон нутгийн төсвөөс	283,352,800.00	283,097,600.00	255,200.00	99.91
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	250,000.00	250,000.00	-	100.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	250,000.00	-	100.00

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>22,695,877.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>22,695,877.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.0	21,285,877.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.0	250,000.00
210104	Урамшуулал	0.0	250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.0	1,319,277.00
210402	Тээвэр, шатахуун	0.0	1,319,277.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.0	19,716,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	19,716,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.0	1410000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.0	1,410,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	0.0	1,410,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.0</b>	<b>23,030,677.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.0</b>	<b>23,030,677.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	23,030,677.00